



**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО**
FINANCIAL REGULATORY COMMISSION
OF MONGOLIA

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
2016ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

**Улаанбаатар хот
2016.06.08**

АГУУЛГА

<i>Нэг. ББСБ-ын салбарын өнөөгийн байдал.....</i>	<i>1</i>
<i>Хоёр. Нэгтгэлийн статистик үзүүлэлт.....</i>	<i>5</i>
2.1 Ерөнхий статистик үзүүлэлт	5
2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ	6
2.3 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ	6
2.4 Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэн явуулж буй ББСБ	7
<i>Гурав. Активын бүтэц, чанар, зээлийн үйл ажиллагаа.....</i>	<i>8</i>
3.1 Активын бүтэц, өөрчлөлт	8
3.2 Зээлийн багцын чанар	9
3.3 Активын бусад үзүүлэлтийн талаар	11
<i>Дөрөв. Пассивын бүтэц, өөрчлөлт</i>	<i>11</i>
<i>Тав. Орлого, зарлага, ашигт ажиллагаа.....</i>	<i>13</i>
<i>Зургаа. Бүлгийн санхүүгийн тоон үзүүлэлтүүд.....</i>	<i>16</i>
<i>Долоо. Салбарын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт</i>	<i>17</i>
<i>Найм. Хууль тогтоомжийн хэрэгжилт.....</i>	<i>18</i>
<i>Ес. Дүгнэлт.....</i>	<i>19</i>

Хавсралт 1: ББСБ-уудын нэгдсэн тэнцэл

Хавсралт 2: Орлого, үр дүнгийн тайлан

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
2016 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2016.06.08

Улаанбаатар хот

НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2016оны 1 дүгээр улиралд 15хуулийн этгээдэд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 2ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгосноор тайлант хугацааны эцэст нийт463 ББСБ Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна.

2006 оны жилийн эцсийн тайлант хугацаанаас хойш ББСБ-уудын тоонд дараах өөрчлөлт орсон байна:

/Хүснэгт 1/

№	Тайлант хугацаа	Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо	Үүнээс:		
			Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ	Зөвхөн гадаад валютын арилжаа эрхэлж буй ББСБ
1	2006 он	139	-	-	-
2	2007 он	137	-	-	-
3	2008 он	132	23	11	-
4	2009 он	177	27	9	47
5	2010 он	182	26	15	48
6	2011он	195	23	17	39
7	2012 он	212	24	17	38
8	2013 он	263	31	19	41
9	2014 он	378	40	23	53
10	2015 он	450	50	27	52
11	2016 оны I улирал	463	52	28	51

Хорооны хуралдаанаар тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын асуудлуудыг шийдвэрлэсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 2/

№	Тайлант хугацаа	Тусгай зөвшөөрөл шинээр олгосон	Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон	Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн	Тусгай зөвшөөрлийг сэргээсэн	Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо
1	2006 он	2	24	-	-	139
2	2007 он	10	12	-	-	137
3	2008 он	10	15	-	-	132
4	2009 он	56	11	15	9	177
5	2010 он	20	15	20	7	182
6	2011он	32	19	14	8	195
7	2012 он	23	6	4	2	212
8	2013 он	54	3	3	1	263
9	2014 он	120	5	5	1	378
10	2015 он	80	8	6	5	450
11	2016 оны I улирал	15	2	0	0	463

Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тооны өөрчлөлтийг графикаар үзүүлбэл:

/График 1/



ББСБ-уудыг Монгол Улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээ эрхэлж буйгаар нь ангилбал:

/Хүснэгт 3/

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо /давхардсан тоогоор/		Өсөлт/бууралт	
		2015-I	2016.I	тоо	хувь
A	Нийт ББСБ-ын тоо	395	463	68	17.2
1	Зээл	339	409	70	17.7
2	Гадаад валютын арилжаа эрхэлдэг нийт	137	140	3	2.1
	Үүнээс: зөвхөн гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг	53	51	(2)	(3.8)
3	Факторингийн үйлчилгээ	16	20	4	24.0
4	Төлбөрийн баталгаа гаргах	10	13	3	30.0
5	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0	0	-	-
6	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	6	7	1	16.7
7	Итгэлцлийн үйлчилгээ	24	27	3	12.5
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	1	(1)	(50.0)
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	25	32	7	28.0

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад энэхүү салбарт оролцогчдын тоо 17.2 хувиар буюу 68 компаниар нэмэгдэж, зээлийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо 17.7 хувь буюу 70 компаниар, факторингийн үйлчилгээ эрхлэгчид 24.0 хувиар буюу 4 компаниар, төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ эрхлэгчдийг тоо 30.0 хувиар буюу 3 компаниар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Мөн нийт ББСБ-ын 88.3 хувь буюу 409 компани зээлийн үйл ажиллагаа, 6.9 хувь буюу 32 компани хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, 5.8 хувь буюу 27 компани итгэлцлийн үйлчилгээ, 4.3 хувь буюу 20 компани факторингийн үйлчилгээ, 2.8 хувь буюу 13 компани төлбөрийн баталгаа гаргах, 1.5 хувь буюу 7 компани цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, 0.2 хувь буюу 1 компани богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээг тус тус эрхэлж байна.

2016 оны 1 дүгээр улирлын байдлаар тайлан ирүүлбэл зохих нийт 463 ББСБ-аас 426 ББСБ буюу 92.0 хувь нь тайлангаа зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж

тайлангийн нэгтгэлд хамруулсан байна.Тайлант хугацаанд эхлэлтийн санхүүгийн тайлангаар 15 ББСБ, өмнөх үеүдийн санхүүгийн тайлангаар 22 ББСБ нэгтгэлд хамрагдсан байна

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

2.1. Ерөнхий статистик үзүүлэлтүүд:

Өмнөх оны мөн үеийн голлох статистик үзүүлэлтүүдийг тайлант хугацаатай харьцуулж харуулбал:

/Хүснэгт 4/


№	Үндсэн үзүүлэлтүүд	2015-I	2016-I	Өөрчлөлт
1	ББСБ-ын тоо	395	463	13
2	Хувьцаа эзэмшигчдийн тоо	830	904	74
3	Ажиллагсадын тоо	1,623	2000	377
4	Салбар нэгжийн тоо	109	121	12
5	Харилцагчдын тоо	405,558	445,918	40,360
6	Нийт актив /мян.төг/	515,905,088.3	634,114,288.0	118,209,199.7
<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>		2.5	2.9	0.4
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мян.төг/	332,153,751.7	400,499,879.8	68,346,128.1
<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>		2.8	3.5	0.7
8	Нийт эзэмшигчдийн өмч /мян.төг/	337,365,010.9	455,585,957.0	118,220,946.1
<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>		14.1	17.5	3.4
9	Нийт хувьцаат капитал /мян.төг/	262,028,450.4	341,261,556.4	79,233,106.0
10	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /мян.төг/	28,454,926.9	29,440,165.36	985,238.46
11	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /мян.төг/	120,803,618.2	110,766,036.4	(10,037,581.7)
	Үүнээс: Богино хугацаат зээл/мян.төг/	63,241,101.2	59,093,506.6	(4,147,594.5)
	Урт хугацаат зээл /мянган төгрөгөөр/	57,562,517.0	51,672,529.8	(5,889,987.2)
12	Төслийн зээлийн санхүүжилт /мян.төг/	13,380,683.8	15,018,326.1	1,637,642.31
13	Нийт орлого /мян.төг/	37,041,478.2	41,023,484.3	3,982,006.1
14	Нийт зардал /мян.төг/	28,097,189.9	33,920,998.6	5,823,808.7
15	Тайлант үеийн ашиг /мян.төг/	8,944,288.3	12,726,729.1	3,782,440.8

Нийт 463 компани банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаагийн 88.8 хувь буюу 411 нь Улаанбаатар хотод, 11.2 хувь буюу 52 нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

Говь-Алтай, Увс аймгуудад ББСБ байгуулагдаагүй байна.

ББСБ-уудын байршлыг үзүүлбэл:

/график 2/



2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ:

Тайлант улиралд орон нутагт төвтэй 52 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 11.2 хувийг, тэдгээрийн актив нь салбарын активын 2.5 хувийг, зээл нь 3.1 хувийг, эзэмшигчдийн өмч нь 3.0 хувийг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь 2.4 хувийг тус тус эзэлж байгаа нь өсөлттэй харагдаж байгаа боловч өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

/Хүснэгт 5/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2015-I	2016.I	Өөрчлөлт
	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	41	52	11
	<i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i>	<i>10.4</i>	<i>11.2</i>	<i>0.8</i>
A	Нийт актив /мян.төг/	13,410,313.4	16,080,263.9	2,669,950.2
	<i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i>	<i>2.6</i>	<i>2.5</i>	<i>(0,1)</i>
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мян.төг/	10,395,206.3	12,271,789.7	1,876,583.4
	<i>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>3.1</i>	<i>3.1</i>	-
	Чанаргүй зээл /мян.төг/	202,164.7	515,570.2	313,405.5
В	Нийт эзэмшигчдийн өмч /мян.төг/	10,400,250.1	13,687,838.9	3,287,588.8
	<i>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</i>	<i>3.1</i>	<i>3.0</i>	<i>(0.1)</i>
Г	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мян.төг/	7,406,730.6	8,096,859.4	690,128.8
	<i>ББСБ-ын нийт хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь</i>	<i>2.8</i>	<i>2,4</i>	<i>(0.4)</i>

2.3 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ:

Тайлант үеийн байдлаар гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 28 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 6.0 хувийг, тэдгээрийн нийт актив ББСБ-ын нийт активын 15.6 хувийг, олгосон зээлийн өрийн үлдэгдэл нийт ББСБ-ын 18.3 хувийг,

эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-уудын эзэмшигчдийн өмчийн 12.3 хувийг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь мөн нийт ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн 12.7 хувийг тус тус эзэлж байна.

/Хүснэгт 6/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2015-I	2016-I	Өөрчлөлт
	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо	22	28	6
	<i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i>	5.6	6.0	0.4
А	Нийт актив /мян.төг/	62,709,620.6	98,998,650.5	36,289,029.9
	<i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i>	12.2	15.6	3.4
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мян.төг/	48,347,000.5	73,150,972.9	24,803,972.4
	Үүнээс: Чанаргүй зээл /мян.төг/	3,772,262.4	9,361,117.2	5,588,854.8
	<i>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	14.6	18.3	3.7
В	Нийт эзэмшигчдийн өмч /мян.төг/	33,298,912.6	55,967,493.6	22,668,581.0
	<i>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</i>	9.9	12.3	2.4
Г	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мян.төг/	25,874,689.4	43,279,091.9	17,404,402.5
	<i>ББСБ-ын нийт хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь</i>	9.9	12.7	2.8

Гадаадын хөрөнгө оруулагчдыг харьяаллаар нь авч үзвэл Япон улсын хөрөнгө оруулалттай 10, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 6, Хятад Хонгконгийн хөрөнгө оруулалттай 2, АНУ, ОХУ, Люксембург, Малайз, Англи, Франц, Швейцар, Сичель улсын хөрөнгө оруулалттай тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

2.4 Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэн явуулж буй ББСБ:

Хорооноос тусгай зөвшөөрөлтэй нийт 463 ББСБ-ын 140 буюу 30.2 хувь нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгаагаас 51 нь зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг дагнан эрхлэх зөвшөөрөлтэй байна.

Гадаад валютын арилжаа дангаар эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 51 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 11.0 хувийг, тэдгээрийн актив нийт ББСБ-ын активын 1.7 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчдийн өмчийн 2.4 хувийг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь нийт ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн 3.1 хувийг тус тус эзэлж байна. Гадаад валютын арилжааны үйл ажиллагааг дагнан эрхэлж буй ББСБ-уудын санхүүгийн голлох үзүүлэлтүүдийг харуулбал дараах байдалтай байна:

/Хүснэгт 7/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2015-I	2016-I	Өөрчлөлт
	Валютын арилжааны үйл ажиллагааг дагнан эрхэлж буй ББСБ-ын тоо	53	51	(2)
	<i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i>	13.4	11.0	(2.4)
А	Нийт актив /мян.төг/	9,977,172.0	11,145,404.0	1,168,232.0
	<i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i>	1.9	1.7	(0.1)
Б	Нийт эзэмшигчдийн өмч /мян.төг/	9,924,975.1	11,048,988.3	1,124,013.2
	<i>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</i>	2.9	2.4	(0.5)
В	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мян.төг/	8,300,242.4	10,530,076.4	2,229,834.0
	<i>ББСБ-ын нийт хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь</i>	3.2	3.1	(0.1)

ГУРАВ. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**3.1 Активын бүтэц, өөрчлөлт:**

Тайлантжилд нийт ББСБ-уудын активын бүтэц өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад дараах байдалтай байна:

/Хүснэгт 8/

№	ХӨРӨНГӨ	2015-I		2016-I		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь
A	Эргэлтийн хөрөнгө	499,175,174.0	96.8	609,045,456.1	96.0	109,870,282.1	22.0
1	Мөнгөн хөрөнгө	139,065,032.5	27.0	178,645,173.9	28.2	39,580,141.4	28.5
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	11,499,916.2	2.2	1,554,237.1	0.2	(9,945,679.1)	(86.5)
3	Нийт зээл	332,153,751.7	64.4	400,499,879.8	63.2	68,346,128.1	20.6
	(Зээлийн эрсдэлийн сан)	18,853,345.7	3.7	30,354,278.8	4.8	11,500,933.1	61.0
4	Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага	0.0	0.0	0.0	0.0	0.0	00
5	Нийт факторингийн тооцооны авлага	90,000.0	0.0	31,227.5	0.0	(58,772.5)	(65.3)
	(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	15,600.0	0.0	30,000.0	0.0	14,400.0	92.3
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	2,007,821.5	0.4	2,072,854.7	0.3	65,033.1	3.2
7	Бусад хөрөнгө	33,227,597.6	6.4	56,626,361.8	8.9	23,398,764.2	70.4
Б	Эргэлтийн бус хөрөнгө	16,729,914.3	3.2	25,068,831.9	4.0	8,338,917.6	49.8
8	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө /цэврээр/	16,729,914.3	3.2	25,068,831.9	4.0	8,338,917.6	49.8
	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	21,750,501.3	4.2	31,333,480.1	4.9	9,582,978.8	44.1
	(Хуримтлагдсан элэгдэл)	5,020,587.0	1.0	6,264,648.2	1.0	1,244,061.1	24.8
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		515,905,088.3	100.0	634,114,288.0	100.0	118,209,199.7	22.9

2016оны 1 дүгээр улирлын байдлаар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 463 ББСБ нь634,114,288.0мянган төгрөгийн актив хөрөнгөтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа ба активын өсөлт нь өмнөх оны мөн үеэс 118,209,199.7мянган төгрөгөөр буюу 22.9 хувиар өссөн байна.


Активын өсөлтийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 3/



Тайлант хугацааны нийт активын 96.0 хувийг эргэлтийн хөрөнгө, 4.0 хувийг эргэлтийн бус хөрөнгө тус тус эзэлж байгаа ба өмнөх онуудтай харьцуулбал дараах байдалтай байна.

/График 4/



Эргэлтийн хөрөнгийн 28.2 хувийг мөнгөн хөрөнгө, 63.2 хувийг олгосон зээлийн өрийн үлдэгдэл тус тус эзэлж байгаа бол нийт мөнгөн хөрөнгийн 43.5 хувийг бэлэн мөнгө, 56.5 хувийг банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж эзэлж байна.

3.2 Зээл, зээлийн багцын чанар:

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна:

/Хүснэгт 9/

№	Ангилал	2015-I		2016-I		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь
1	Хэвийн	284,258,967.3	85.6	325,575,141.9	81.3	41,316,174.6	14.5
2	Хугацаа хэтэрсэн	23,603,857.3	7.1	29,212,887.9	7.3	5,609,030.6	23.8
3	Чанаргүй зээл. Үүнээс	24,290,927.1	7.3	45,711,850.0	11.4	21,420,922.9	88.2
	Хэвийн бус	6,477,565.8	2.0	13,244,179.1	3.3	6,766,613.3	104.5
	Эргэлзээтэй	6,527,830.3	2.0	12,442,778.9	3.1	5,914,948.6	90.6
	Муу	11,285,531.0	3.4	20,024,892.1	5.0	8,739,361.1	77.4
	(Зээлийн эрсдэлийн сан)	18,853,345.7	5.7	30,354,278.8	7.6	11,500,933.1	61.0
Нийт зээл		332,153,751.7	100.0	400,499,879.8	100.0	68,346,128.1	20.6
Үүнээс: Төгрөгөөр олгосон зээл		297,632,252.8	89.6	367,018,172.0	91.6	69,385,919.2	23.3
Үүнээс: Гадаад валютаар олгосон зээл		34,521,498.8	10.4	33,481,707.9	8.4	(1,039,790.9)	(3.0)


Тайлант үеийн зээлийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл, нийт зээлийн хэмжээ 68.3 тэрбум төгрөгөөр буюу 20.6 хувиар өссөн байна.

Зээлийн бүтцийн хувьд нийт зээлд төгрөгөөр олгосон зээлийн эзлэх хувь өмнөх оны мөн 69.4 тэрбум төгрөгөөр буюу 23.3 хувиар өсч, гадаад валютаар олгосон зээл 1.03 тэрбум төгрөгөөр буюу 2.0 хувиар буурсан байна.

Мөн нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн ангиллын төрөл тус бүрийн хэмжээ нэмэгдсэн, нийт чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 21.4 тэрбум төгрөгөөр буюу 88.2 хувиар өссөн байна. Чанаргүй зээлийн хэмжээ, түүний дотор муу зээлийн хэмжээ 2 дахин нэмэгдсэнтэй холбогдон зээлийн эрсдэлээс хамгаалах сан өмнөх оны мөн үеэс 11.5 тэрбум төгрөгөөр буюу 61.0 хувиар өссөн байна.

ББСБ-уудын нийт зээлийн багцын бүтцийг өмнөх онуудтай харьцуулбал дараах байдалтай байна.


/График 5/



Тайлант хугацаанд нийт 409 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгаагаас 72.1 хувь буюу 295 ББСБ зөвхөн зээлийн үйл ажиллагааг дагнан эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.

Нийт зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 409 ББСБ-аас 82.3 хувь буюу 381 нь зээлийн өрийн үлдэгдэлтэй байгаа ба 400,499,879.8 мянган төгрөгийн нийт зээлийн багцын 11.4 хувийг чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл эзэлж байна. Нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оны мөн үеэс 4.1 хувиар өссөн байна.

/График 6/



3.3 Активын бусад үзүүлэлтийн талаар:

Богино хугацаат хөрөнгө оруулалтын /цэврээр/ дансны үлдэгдэлд 1,554,237.1 мянган төгрөг байна. Үүнд

/Хүснэгт 10/

д/д	Богино хугацаат хөрөнгө оруулалтын төрөл	Хэмжээ /мянган төгрөг/	Богино хугацаат хөрөнгө оруулалтад эзлэх хувь
1	Арилжааны үнэт цаас	370,349.4	23.8
2	Хөрөнгө оруулалтын үнэт цаас	1,183,887.7	76.2
3	Үнэт цаасны хорогдуулаагүй нэмэгдэл, хямдруулалт	0.00	0.00
	НИЙТ	1,554,237.1	100.0

Факторингийн тооцооны нийт авлагын 96.1 хувь нь буюу 30,000.0 мянган төгрөг нь муу авлагад ангилагдан 30,000.0 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулж буй 463 ББСБ-д 31,333,480.1 мянган төгрөгийн үндсэн ба биет бус хөрөнгө бүртгэгдсэн ба тэдгээрт 6,264,648.2 мянган төгрөгийг хуримтлагдсан элэгдэл тооцон нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байна.

ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ

2016 оны I дүгээр улиралд ББСБ-уудын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

/Хүснэгт 11/


№	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	2015-I		2016-I		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь
A	Нийт өр төлбөр	178,540,077.4	34.6	160,585,149.5	25.3	(17,954,927.9)	(10.1)
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	28,454,926.9	5.5	29,440,165.4	4.6	985,238.5	3.5
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	120,803,618.2	23.4	110,766,036.4	17.5	(10,037,581.8)	(8.3)
3	Бусад эх үүсвэр	3,170,076.1	0.6	4,145,417.2	0.7	975,341.1	30.8
	<i>Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр</i>	82,586.2	0.0	0.0	0.0	(82,586.2)	(100.0)
	<i>Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг</i>	3,086,364.7	0.6	1,582,638.9	0.2	(1,503,725.8)	(48.7)
	<i>Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг</i>	1,125.2	0.0	2,562,778.4	0.4	2,561,653.2	227,662.0
	<i>Факторингийн үйлчилгээний өглөг</i>	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
	<i>Гадаад валютын арилжааны эх үүсвэр</i>	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	885,400.0	0.2	1,215,204.4	0.2	329,804.4	37.2
5	Төслийн зээлийн санхүүжилт	13,380,683.9	2.6	15,018,326.1	2.4	1,637,642.2	12.2
6	Бусад өр төлбөр	11,845,372.3	2.3	17,943,181.5	2.8	6,097,809.2	51.5
	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	4,010,706.2	0.8	4,714,272.6	0.1	703,566.4	17.5
	Бусад пассив	7,834,666.2	1.5	13,228,908.9	2.1	5,394,242.7	68.9
Б	Эзэмшигчдийн өмч	337,365,010.9	65.4	455,585,957.0	71.8	118,220,946.1	35.0
7	Хувьцаат капитал	262,028,450.4	50.8	341,261,556.5	53.8	79,233,106.1	30.2
8	Бусад өмч	7,496,688.3	1.5	11,225,318.0	1.8	3,728,629.7	49.7
9	Сангууд	350,917.1	0.1	492,395.0	0.1	141,477.9	40.3
10	Хуримтлагдсан ашиг/алдагдал	65,694,088.8	12.7	101,792,931.8	16.1	36,098,843.0	54.9
11	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	1,794,866.3	0.3	813,755.8	0.1	(981,110.5)	(54.7)
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ		515,905,088.3	100.0	634,114,288.0	100.0	118,209,199.7	22.9

Нийт эх үүсвэрийн 25.3 хувийг нийт өр төлбөр, 71.8 хувийг эзэмшигчдийн өмч эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 10.1 хувиар буурч, эзэмшигчдийн өмч 35.0 хувиар өссөн байна.

ББСБ-уудын системийн нийт пассивын хэмжээг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 7/



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 10.1 хувиар ба үүнээс дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл 8.3, бусад өр төлбөр 51.5 хувиар буурч, итгэлцлийн үйлчилгээний өглөг 3.5, бусад эх үүсвэр 30.8, төслийн зээлийн санхүүжилт 12.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй гарсан байна.

Харин эзэмшигчдийн өмчийн хувьд 35 хувиар өссөнөөс хувьцаат капитал 30.2, сангууд 40.3, хуримтлагдсан ашгийн үзүүлэлт 54.9 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Итгэлцлийн үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 27 ББСБ байгаагаас нэр бүхий 20 ББСБ итгэлцлээр 29,440,165.4 мянган төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлсэн байна.

Бусад нэр бүхий 2 ББСБ нь 1,582,638.9 мянган төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгтэй байна.

Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 7 ББСБ-ын нийт актив 24,289,716.6 мянган төгрөг байгаа нь салбарын нийт активын 3.8 хувийг, нийт эзэмшигчдийн өмчийн дүн 16,749,903.3 мянган төгрөг байгаа нь салбарын мөн үзүүлэлтийн 3.7 хувийг, төлбөр тооцооны үйлчилгээний өглөг 2,562,778.4 мянган төгрөг байгаа нь салбарын нийт өглөгийн 1.6 хувьтай тэнцэж байна.

Тайлант хугацаанд Хорооны зөвшөөрөлтэйгөөрхаалттай өрийн бичиг гаргасан 2 ББСБ нь нийт 1,215,204.4 мянган төгрөгийн өрийн бичгийн үлдэгдэлтэй байна.

2016 оны 1 дүгээр улирлын байдлаар 7 ББСБ-д 813,755.8 мянган төгрөгийн хоёрдогч өглөг бүртгэгдсэн байна.

ТАВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

2016 оны 1 дүгээр улирлын байдлаар ББСБ-уудын нийт орлого өмнөх оны мөн үеэс 10.8 хувиар өссөн ба дараах бүтэцтэй байна.

/Хүснэгт 12/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2015-I		2016-I		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь
1	ХҮҮГИЙН ОРЛОГО	26,626,277.1	71.9	33,457,950.4	81.6	6,831,673.3	25.7
	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	25,501,022.6	68.8	31,399,675.7	76.5	5,898,653.1	23.1
	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	607,886.1	1.6	1,407,502.2	0.0	799,616.1	131.5
	Үнэт цаасны хүүгийн орлого	0.0	0.0	1,669.0	0.0	1,669.0	
	Бусад хүүгийн орлого	517,368.4	1.4	649,103.5	1.6	131,735.1	25.5
2	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО	9,951,020.4	26.9	6,822,802.8	16.6	(3,128,217.6)	(31.4)
3	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	442,410.2	1.2	738,269.9	1.8	295,859.7	66.9
4	ЕРДИЙН БУС ОРЛОГО	21,770.5	0.1	4,461.2	0.0	(17,309.3)	(79.5)
	НИЙТ ОРЛОГО	37,041,478.2	100.0	41,023,484.3	100.0	3,982,006.1	10.8

Тайлант хугацааны нийт орлогын 81.6 хувийг хүүгийн орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн орлогын дүнтэй харьцуулахад 25.7 хувиар өссөн/, 16.6 хувийг хүүгийн бус орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн бус орлогын дүнтэй харьцуулахад 31.4 хувиар буурсан/ эзэлж байна.

Хүүгийн бус орлого өмнөх оны мөн үеэс 31.4 хувиар буурсан ба дараах бүтэцтэй байна.

/Хүснэгт 13/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2015-I		2016-I		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь
1	Арилжааны орлого	845,453.3	8.5	733,859.4	10.8	(111,593.9)	(13.2)
1.1	Гадаад валютын арилжааны орлого	844,603.3	8.5	733,859.4	10.8	(110,743.9)	(13.1)
1.2	Үнэт цаасны арилжааны орлого	850.0	0.0	0.0	0.0	(850.0)	(100.0)
2	Ханш болон үнэлгээний тэгшигтгэлийн орлого	7,384,454.6	74.2	4,355,562.6	63.8	(3,028,892.0)	(41.0)
2.1	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	7,104,332.6	71.4	4,355,562.6	63.8	(2,748,770.0)	(38.7)
2.2	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	280,122.0	2.8	0.0	0.0	(280,122.0)	(100.0)
3	Санхүүгийн үйлчилгээний орлого	1,721,112.5	17.3	1,733,380.8	25.4	12,268.3	0.7
3.1	Санхүүгийн түрээсийн орлого	2,187.5	0.0	0.0	0.0	(2,187.5)	(100.0)
3.2	Итгэлцлийн үйлчилгээний орлого	16,657.8	0.2	0.0	0.0	(16,657.8)	(100.0)
3.3	Мөнгөн гуйвуулгын орлого	226,281.7	2.3	114,576.0	1.7	(111,705.7)	(49.4)
3.4	Картын үйлчилгээний орлого	60.0	0.0	120.0	0.0	60.0	100.0
3.5	Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	179,819.7	1.8	48,211.4	0.7	(131,608.3)	(73.2)
3.6	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	1,049,066.8	10.5	1,108,953.0	16.3	59,886.2	5.7
3.7	Бусад	247,039.1	2.5	461,520.3	6.8	214,481.2	86.8
	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО НИЙТ	9,951,020.4	100.0	6,822,802.8	100.0	(3,128,217.6)	(31.4)

Тайлант үеийн байдлаар ББСБ-уудын нийт зардал өмнөх оны мөн үеэс 7.7 хувиар өссөн ба дараах бүтэцтэй байна:

/Хүснэгт 14/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2015-I		2016-I		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь
1	ХҮҮГИЙН ЗАРДАЛ	4,106,631.5	14.6	4,276,359.9	15.1	169,728.4	4.1
2	ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ	18,156,059.8	64.6	16,551,314.0	58.5	(1,604,745.8)	(8.8)
3	БОЛЗОШГУЙ ЭРСДЭЛИЙН ЗАРДАЛ	4,293,748.0	15.3	5,630,693.3	19.9	1,336,945.3	31.1
4	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	230,626.8	0.8	212,015.8	0.7	(18,611.0)	(8.1)
5	ЕРДИЙН БУС ЗАРДАЛ	12,232.8	0.0	0.0	0.0	(12,232.8)	(100.0)
6	ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ	1,297,891.0	4.6	1,626,372.2	5.7	328,481.2	25.3
	НИЙТ ЗАРДАЛ	28,097,189.9	100.0	28,296,755.2	100.0	199,565.29	0.7

Өмнөх үеийн мөн үетэй харьцуулахад тайлант хугацааны хүүгийн зардал 4.1 хувиар өссөн бол хүүгийн бус зардал 8.8 хувиар буурсан байна.


Тайлант хугацаанд нийт 12,726,729.1мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 42.3 хувиар өссөн байна.

/Хүснэгт 15/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2015-I	2016-I	Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Дүн /мян.төг/	Дүн /мян.төг/	Хувь
1	НИЙТ ОРЛОГО	37,041,478.2	41,023,484.3	3,982,006.1	10.8
2	НИЙТ ЗАРДАЛ	28,097,189.9	28,296,755.2	199,565.3	0.7
3	ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ	8,944,288.3	12,726,729.1	3,782,440.8	42.3

ББСБ-уудын нийт орлого, зардлын үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна:

/График 8/



Тайлант жилд 349 ББСБ буюу нийт ББСБ-ын 75.4 хувь нь 14,976,320.9мянган төгрөгийн ашигтай, 80 ББСБ буюу нийт ББСБ-уудын 17.2хувь нь 2,249,591.8мянган төгрөгийн алдагдалтай ажилласан бол 34 ББСБ буюу нийт ББСБ-ын 7.3 хувь нь эхлэлтийн болон “Х” тайлан буюу үйл ажиллагаа явуулаагүй тухай тайлангаар нэгтгэлд хамрагдсан байна./тайлант хугацаанд ашигтай, алдагдалтай ажилласан ББСБ-уудын санхүүгийн голлох үзүүлэлтүүдийг нэгтгэлийн танилцуулгад хавсралт 2, 3, 4–т хавсаргав/.

Тэнцлийн гадуурх дансны нийт үлдэгдэл 448,660,682.2 мянган төгрөг байгаагаас үнэ бүхий зүйл 410,479,457.8 мянган төгрөг зээл болон бусад хөрөнгийн тооцооны үлдэгдэл 3,518,847.4 мянган төгрөг байна.

Тэнцлийн гадуурх дансны бүтэц дараах байдалтай байна. /Хүснэгт 16/

№	Дансны төрөл	Дүн	Хувь
1	Тэнцлийн гадуурх дансны нийт үлдэгдэл	448,660,682.2	100.0
2	<i>Хүлээж болзошгүй үүрэг Үүнээс:</i>	34,662,376.9	7.7
	Батлан даалт	34,147,403.4	7.6
	Зээлийн шугам	514,973.6	0.1
3	<i>Үнэ бүхий зүйл Үүнээс:</i>	410,479,457.8	91.5
	Зээлийн барьцаа хөрөнгө	404,636,362.4	90.2
	Хадгалсан үнэ бүхий зүйл	5,177,054.5	1.2
	Борлуулсан үнэт цаас	13.8	0.0
	Үнэт цаас, чекийн загвар	108.4	0.0
	Хэрэглэж буй тэмдэгүүд	1,536.4	0.0

	Цахим карт	0.0	0.0
	Нарийн бүртгэлтэй маягтууд	81.9	0.0
	Бусад	664,300.4	0.1
4	Зээл болон бусад хөрөнгийн тооцоо Үүнээс:	3,518,847.4	0.8
	Үнэт цаасны эрсдэлийн сангаас хаасан авлага	107,300.0	0.0
	Зээлийн эрсдэлийн сангаас хаасан зээл	1,257,457.0	0.3
	Факторингийн эрсдэлийн сангаас хаасан авлага	-	-
	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн хасагдуулгаар хассан хөрөнгө	172,960.0	0.0
	Авлагын эрсдэлийн сангаас хаасан авлага	74,871.2	0.0
	Хуримтлуулж тооцохыг зогсоосон үнэт цаасны хүү	-	-
	Хуримтлуулж тооцохыг зогсоосон зээлийн хүү	1,906,259.2	0.4
	Хуримтлуулж тооцохыг зогсоосон факторингийн хүү	-	-

ЗУРГАА. БҮЛГИЙН САНХҮҮГИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийт ББСБ-уудыг активын хэмжээгээр нь 400,000.0 мянган төгрөг хүртэл 400,000.0 мянган төгрөгөөс 1.0 тэрбум төгрөг хүртэл, 1.0 тэрбум төгрөгөөс 5.0 тэрбум төгрөг хүртэл, 5.0 тэрбум төгрөг ба түүнээс дээш төгрөгийн активтай гэсэн 4 бүлэгт ангилан тооцов.2016 оны 1 дүгээр улирлын байдлаар бүлгүүдийн бүтэц дараах байдалтай байна:

/Хүснэгт 17/

№	Бүлэг	Бүлэгт хамаарах ББСБ-ын тоо	Бүлгийн нийт актив		Нэмэлт мэдээлэл
			Актив /мянган төгрөг/	Нийт активт эзлэх хэмжээ /хувь/	
1	Бүлэг 1	23	293,424,306.3	46.3	5.0 тэрбум ба түүнээс дээш төгрөгийн активтай
2	Бүлэг 2	105	194,164,752.8	30.6	1.0 тэрбумаас 5.0 тэрбум төгрөг хүртэлх активтай
3	Бүлэг 3	224	128,757,764.8	20.3	400,000.0 мянган төгрөгөөс 1.0 тэрбум төгрөг хүртэл хэмжээний активтай
4	Бүлэг 4	111	17,767,464.1	2.8	400,000.0 мянган төгрөг хүртэл хэмжээний активтай
НИЙТ		463	634,114,288.0	100.0	

Бүлгүүдийн санхүүгийн голлох үзүүлэлтүүд дараах байдалтай байна:

/Хүснэгт 18/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	БҮЛЭГ 1	БҮЛЭГ 2	БҮЛЭГ 3	БҮЛЭГ 4	НИЙТ
1	Нийт хөрөнгө /мян.төг/	293,424,306.3	194,164,752.8	128,757,764.8	17,767,464.1	634,114,288.0
	Салбарын нийт активт эзлэх хувь	46.3	30.6	20.3	2.8	100.0
2	Нийт зээл /мян.төг/	189,867,244.9	129,319,172.7	76,495,824.1	4,817,638.1	400,499,879.8
	Салбарын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	47.4	32.3	19.1	1.2	100.0
3	Нийт өр төлбөр /мян.төг/	132,863,680.4	25,622,414.4	1,976,954.9	122,099.9	160,585,149.5
	Салбарын нийт өр төлбөрт эзлэх хувь	82.7	16.0	1.2	0.1	100.0
4	Эзэмшигчдийн өмч /мян.төг/	152,231,327.3	162,199,611.8	123,765,431.5	17,389,586.4	455,585,957.0
	Салбарын нийт	33.4	35.6	27.2	3.8	100.0

эзэмшигчдийн өмчид эзлэх хувь						
5	Хувьцаат капитал /мян.төг/	90,223,351.2	130,307,243.4	103,788,737.5	16,942,224.4	341,261,556.5
Салбарын нийт хувьцаат капиталд эзлэх хувь		26.4	38.2	30.4	5.0	100.0
6	Тухайн үеийн ашиг/алдагдал /мян.төг/	5,516,458.2	4,427,500.3	2,654,794.1	127,976.5	12,726,729.1
Салбарын нийт тайлант үеийн ашигт эзлэх хувь		43.3	34.8	20.9	1.0	100.0

2016 оны 1 дүгээр улирлын байдлаар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй 463 ББСБ-ын 4.9 хувийг 5.0 тэрбум ба түүнээс дээш актив хөрөнгөтэй 23 ББСБ эзэлж байгаа ба тэдгээр нь нийт ББСБ-уудын активын 46.3 хувь, зээлийн өрийн үлдэгдлийн 47.4 хувь, нийт өр төлбөрийн 82.7 хувь, эзэмшигчдийн өмчийн 33.4 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгийн 26.4 хувь, тайлант үеийн ашгийн 43.3 хувийг тус тус эзэлж байна.

ББСБ-уудын 22.7 хувийг 1.0 тэрбум төгрөгөөс 5.0 тэрбум төгрөг хүртэл хэмжээний активтай 105 ББСБ эзэлж байгаа ба тэдгээр нь нийт ББСБ-уудын активын 30.6 хувь, зээлийн өрийн үлдэгдлийн 32.3 хувь, нийт өр төлбөрийн 16.0 хувь, эзэмшигчдийн өмчийн 35.6 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгийн 38.2 хувийг бүрдүүлж байгаа ба тус бүлгийн хувьд 913,671.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь салбарын нийт алдагдлын 40.6 хувийг эзэлж байна.

Нийт ББСБ-уудын 48.4 хувийг 400,000.0 мянган төгрөгөөс 1.0 тэрбум төгрөг хүртэл хэмжээний активтай 224 ББСБ эзэлж байгаа ба тэдгээр нь нийт ББСБ-уудын активын 20.3 хувь, зээлийн өрийн үлдэгдлийн 19.1 хувь, нийт өр төлбөрийн 1.2 хувь, эзэмшигчдийн өмчийн 27.2 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгийн 30.4 хувийг бүрдүүлж байна.

Мөн ББСБ-уудын 24.0 хувийг 400,000.0 мянган төгрөг хүртэл хэмжээний активтай 111 ББСБ эзэлж байгаа ба тэдгээр нь нийт ББСБ-уудын активын 2.8 хувь, зээлийн өрийн үлдэгдлийн 1.2 хувь, нийт өр төлбөрийн 0.1 хувь, эзэмшигчдийн өмчийн 3.8 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгийн 5.0 хувийг тус тус бүрдүүлж байна.

ДОЛОО. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Тайлант хугацаанд ББСБ-уудын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд салбарын дүнгээр ханган ажиллаж байгаа боловч үйл ажиллагаа явуулж буй 463 ББСБ нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хэрхэн ханган ажилласан нь дараах байдалтай байна¹.

/Хүснэгт 19/

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Нийт ББСБ-д эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	364	78.6
2	1 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	75	16.2
3	2 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	17	3.7
4	3 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	4	0.9
5	4 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	1	0.2
6	5 ба дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	2	0.4
Нийт		463	100.0

Мөн ББСБ-уудын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хангалт дараах байдалтай байна:

-Нийт өөрийн хөрөнгө 455,585,957.0 мянган төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 537,404,735.2 мянган төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлага 84.4 хувиар, өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлага 85.0 хувиар, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлага 67.8 хувиар;

-Нийт түргэн борлогдох актив 178,926,413.4 мянган төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 172,231,784.5 мянган төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлага 103.9 хувиар;

-Валютын дансны цэвэр зөрүү 5,516,043.0 мянган төгрөг, тухайн валютаарх өөрийн хөрөнгө 222,717,764.7 мянган төгрөг байгаагаас нийт гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 2.48 хувиар;

-Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 29,440,165.4 мянган төгрөг, өөрийн хөрөнгө 455,585,957.0 мянган төгрөг байгаагаас итгэлцлийн үйлчилгээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 80 хувиас ихгүй байх шаардлага 6.4 хувиар;

-Нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 11,293,063.5 мянган төгрөг, нийт актив 634,114,288.0 мянган төгрөг байгаагаас үндсэн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 15 хувиас ихгүй байх шаардлага 1.8 хувиар;

-Гаргасан хаалттай өрийн бичгийн үлдэгдэл 1,215,204.4 мянган төгрөг, өөрийн хөрөнгө 455,585,957.0 мянган төгрөг байгаагаас хаалттай өрийн бичгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 50 хувиас ихгүй байх шаардлага 50 хувиар тус тус биелсэн;

Харин зээлийн эрсдэлийн санг 30,354,278.8 мянган төгрөгөөр байгуулсан байна.

НАЙМ. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

1. Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллагууд Монголбанкны Зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулан, зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүрэгтэй. Тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 463 ББСБ-ын 61.8 хувь буюу 256 ББСБ энэ үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.

2. Тайлант хугацаанд нийт 463 ББСБ-аас 572,475.0 мянган төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны дансанд төвлөрүүлэхээс 2016 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 264 ББСБ 376,030.9 мянган төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төвлөрүүлсэн нь 66.0 хувийн биелэлттэй байна.

3. Аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хөндлөнгийн аудитаар баталгаажуулж, нийтэд мэдээлэх үүргийг оны эхэнд үйл ажиллагаа эрхэлж байсан 463 ББСБ -ын 55.1 хувь буюу 255 ББСБ хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна.

ЕС. ДҮГНЭЛТ

1. 2016 оны 1 дүгээр улиралд нийт ББСБ-ын 92.0 хувь буюу 426 ББСБ санхүүгийн тайлангаа ирүүлж нэгтгэлд хамруулсан ба нэр бүхий 15 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлийн, 22 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлийн үзүүлэлтээр хамрагдсан байна.

2. Тайлант хугацаанд ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 13 компаниар буюу 3.3 хувиар, хувьцаа эзэмшигчдийн тоо 74-өөр буюу 8.9 хувиар нэмэгдсэн байна. Салбарт ажиллагсдын тоо 377-оор нэмэгдэж 2000-д хүрч, харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 41,068-аар буюу 10.1 хувиар өссөн байна.

3. Улсын хэмжээнд 463 компани банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаагийн 88.8 хувь буюу 411 нь УБ хотод, 11.2 хувь буюу 52 нь Говь-Алтай, Увс, аймгуудаас бусад орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

4. Тайлант хугацаанд ББСБ-уудын нийт актив 634.1 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 2.9 хувьтай, зээлийн өрийн үлдэгдэл 400.5 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 3.5 хувьтай, эзэмшигчдийн өмч 455.6 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 17.5 хувьтай, хувь нийлүүлсэн хөрөнгө 341.3 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 45.4 хувьтай тус тус тэнцэж байна.

5. ББСБ-уудын зарим үндсэн үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт актив 118.2 тэрбум төгрөгөөр буюу 22.9 хувиар, нийт активт эзлэх зээлийн хэмжээ 68.3 тэрбум төгрөгөөр буюу 20.6 хувиар, эзэмшигчдийн өмч 118.2 тэрбум төгрөгөөр буюу 35.0 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгө 79.2 мянган төгрөгөөр буюу 30.2 хувиар тус тус өссөн байна.

6. ББСБ-уудын өр төлбөрийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад итгэлцлийн үйлчилгээний өглөг 1.0 тэрбум төгрөгөөр буюу 3.5 хувиар өсч, банк, банк бус санхүүгийн байгууллагын зээлийн өглөг 10.0 тэрбум төгрөгөөр буюу 8.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

7. Тайлант үеийн зээлийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл нийт зээлийн хэмжээ 68.3 тэрбум төгрөгөөр буюу 20.6 хувиар өссөн байна.

Зээлийн бүтцийн хувьд нийт зээлд төгрөгөөр олгосон зээлийн эзлэх хувь өмнөх оны мөн 69.4 тэрбум төгрөгөөр буюу 23.3 хувиар өсч, гадаад валютаар олгосон зээл 1.03 тэрбум төгрөгөөр буюу 2.0 хувиар буурсан байна.

Мөн нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн ангиллын төрөл тус бүрийн хэмжээ нэмэгдсэн, нийт чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 21.4 тэрбум төгрөгөөр буюу 88.2 хувиар өссөн байна. Чанаргүй зээлийн хэмжээ, түүний дотор муу зээлийн хэмжээ 2 дахин нэмэгдсэнтэй холбогдон зээлийн эрсдэлээс хамгаалах сан өмнөх оны мөн үеэс 11.5 тэрбум төгрөгөөр буюу 61.0 хувиар өссөн байна.

8. ББСБ-ууд тайлант хугацаанд нийт 14,976,320.9 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3.1 тэрбум төгрөгөөр буюу 25.8 хувиар өссөн байна.

Нийт ББСБ-ын 349 ББСБ буюу 75.4 хувь нь 14,976,320.9 мянган төгрөгийн ашигтай, 80 ББСБ буюу 17.2 хувь нь 2,249,591.8 мянган төгрөгийн алдагдалтай, 35 ББСБ буюу 7.5 хувь нь үйл ажиллагаа явуулаагүй байна.

9. ББСБ-ын зээлийн хүүг банкны зээлийн хүүтэй харьцуулбал хоёр дахин буюу ББСБ-ын дундаж хүү 3.5 хувьтай байна. Зохицуулалтын газрын зүгээс зээлийн хүү, эх үүсвэрийн өртгийг бууруулах, зээлийн хүү тооцох аргачлал, журам боловсруулах чиглэлээр судалж, холбогдох санал дүгнэлтийг боловсруулж ажиллахаар жилийн ажлын төлөвлөгөөнд тусгаад судалгаа хийгдэж байна.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР